



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар A/17

Хөхөө

**Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх,
түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.12, 18.2.14 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг өөрийн харьяа баг, байгууллага дээрээ зохион байгуулж, гарсан тохиолдолд унтраах ажилд оролцох 1,2 дугаар ээлжинд ажиллах хүн хүч, хэрэгслийг томилсон захирамж, тушаал гарган ажиллахыг баг, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

2.Ой хээрийн түймэр гарах магадлал өндөр газруудад морин эргүүл гаргах, газар нутгийг иргэд, нөхөрлөлүүдэд хариуцуулах баг бүрт идэвхтэн байгаль хамгаалагч томилон ажиллуулахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Батжаргал), Багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Ой хээрийн түймэр гарсан тохиолдолд унтраах ажилд шаардагдах шатахуун, гурав хоногийн хоол, багаж хэрэгслийн нөөцийг бэлтгэж Аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Баасанжав)-д даалгасугай.

4.Гал түймрийн аюултай үе болох 3 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын сарын 10, 9 дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 10 хүртэлх хугацаанд онцгой шаардлагагүйгээр ойд нэвтрэх, ан гөрөө, аялал зугаалга хийхгүй байх, түймэр гарсан үед мэдээллийг цаг алдалгүй холбогдох хүмүүст дамжуулан ажиллахыг нийт иргэдэд анхааруулсугай.

5.Ой хээрээр явж бугын ясан эвэр түүх, мод бэлтгэх, эрэл хайгуул хийх, аялал зугаалгаар явж буй иргэдийн бүртгэл судалгааг гаргаж 7 хоног бүрт Байгаль

670800100053

орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасагт мэдээлэл ирүүлж байхыг Аж ахуйн нэгж, баг, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

6.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Орлогч (З.Анхсанчир)-д даалгасугай.

ДАРГА



Л. ЭНХЖАРГАЛ